

# Учир шалтгааныг тайлбарласан, дүрслэн тайлбарласан, тоочин тайлбарласан эхийн сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрээр тодорхойлох

- Тоочин тайлбарласан эхийн утга,  
бүтцийг тодорхойлох
- Тоочин тайлбарласан эхийн сэдэв, гол  
санааг түлхүүр үг, өгүүлбэрээр  
тодорхойлох
- Үгийн сан, өгүүлбэр зүйн  
онцлогийг шинжлэх



# “Их газарын чулуу” эхийг уншаад, танил бус үгийн утгыг дэвтэртээ тэмдэглэж аваарай.



байц – хавцал бэрх газар

таг- уулын хавтгайвтар орой



өлхөн - уужим, чөлөөтэй


## Их газарын чулуу

Их газарын чулуу нь Дундговь аймгийн Говь-Угтаал, Гурвансайхан сумын уулзварт эргэн тойрон заримдаг цөлийн хөндий хоолойгоор хүрээлэгдэн, 600 шахам ам километр талбайг эзлэн оршдог бөгөөд боржин, асмалжин, толбожин гэх мэтийн гүний, перм, цэрд, гурав дахь галвын элсэн чулуу, нүүрслэг занар, шохой, алаг мөлгөр хөрзөн зэрэг чулуулгаас бүтсэн, уртаараа 30 орчим, өргөөшөө 15 км сунасан, хойноос урагшаа, баруунаас зүүн тийшээ гудамлан эгнэсэн **байц** тогтоцтой. Байгалийн үзэсгэлэн, газар зүйн онцлогийг нь хадгалах зорилгоор 2003 онд УИХ-ын 30-дугаар тогтоолоор улсын тусгай хамгаалалтад авчээ.

Энэ нь далайн түвшнээс 1565-1709 метр өндөрт оршдог уул. Өлзий, Сүмбэр, Баян уул, Хайрхан зэрэг ноёлог өндөрлөгүүдтэй. Өвгөн хад, Сэнжит хад, Хаан хатан, Хайлсман, Тувин, Гуа өлгий, Монгол, Баян уул, Ёрвон гэх мэт өвөрмөц хэлбэр тогтоц бүхий байц хад олонтой. Баганат, Гимбэл, Жирэг зэрэг хэд хэдэн **таг**тай бөгөөд нэг нь хэдэн азарга адуу **өлхөн** багтах зайтай Хур харцагын таг юм. Өлгий, Бунхант, Шинэ ус, Тоонот гэх мэт их бага нийлсэн 40 гаруй агуйтай бөгөөд хамгийн том нь 30 метр урт, 3,5 метр өргөн, 10 метр өндөр Тантааны бааст хэмээх агуй юм.

# “Их газарын чулуу” эхийг уншихдаа танил бус үгийг тэмдэглээд, толь ашиглан тайлбарлаарай.

гиваан-шар өнгөтэй шороо, чулуу



билүү-бага ширхэгтэй зөөлөн чулуу



Эл газар нь усан болор, утаат болор, хаш, мана, хайлуур жонш, **гиваан**, төмөр, зэс, **билүү**, занар, шороон будаг зэрэг металл, металл бус ашигт малтмал ихтэй.

Энд байгалийн завсрын бүсийн болон нэн ховор ургамлууд зонхилж ургана. Хазаар өвс, хялгана, таана, хөмөл, бударгана зэрэг говь хээрийн бэлчээрийн ургамлаас гадна алтан гагнуур, гичгэнэ, хунчир, далайн түрүү зэрэг гучаад нэрийн эмийн ургамалтай.

Мөн нэлээд олон зүйлийн ан амьтадтай. Алаг даага, хадны борогчин, монгол чижүүл зэрэг мэрэгчид, сахалт багваахай, жижиг соотон багваахай зэрэг гар далавчтан, тас, бүргэд, харцага, ногтруу, хээрийн тагтаа, болжмор зэрэг жигүүртэн, аргаль, янгир, шилүүс, үнэг, хярс, тарвага, туулай зэрэг хорь гаруй төрлийн хөхтөн амьдардаг.

Их газарын чулуу уул нь өвөрмөц сонин тогтоц бүхий байгалийн урлал юм.

# Эхийн агуулгын бүтэц, утгыг тодорхойлоорой. Гүйцээнэ үү.

Агуулгын хэсэг тус бүрийг зааглах



Хэсэг тус бүрд аль аль цогцолбор хамаарч байгааг тодорхойлох



Цогцолбор тус бүрд юуны тухай тайлбарласныг тодорхойлох

Агуулгын бүтэц	Хэсгийн зааг	Цогцолборын дугаар	Эхэд тайлбарлагдаж буй юм
Эхлэл хэсэг			Их газарын чулуу, тогтоц,
Гол хэсэг	Энэ нь далайн түвшнээс .... хөхтөн амьдардаг.		Уул, ашигт малтмал, ургамал, амьтан
Төгсгөл хэсэг	Их газарын чулуу уул нь байгалийн өвөрмөц сонин тогтоц бүхий байгалийн урлал юм.	6	

# Эхийн цогцолбор тус бүрээс түлхүүр үгийг олоорой.

Цогцолбор бүрд хамгийн олон тохиолдсон үгийг тэмдэглэх



Цогцолбор бүрийн утгыг илэрхийлэх чухал үгийн доогуур зурах

Цогцолборын дугаар	Түлхүүр үг
I	Их газарын чулуу, тогтоц, үзэсгэлэн, газар зүйн онцлог, хамгаалалт
II	
III	
IV	
V	
VI	

Түлхүүр үг гэдэг нь эхэд олон давтагдаж орсон болон эхийн утгыг гаргахад чухал үүрэгтэй үг хэллэгийг хэлнэ. Түлхүүр үг нь ихэвчлэн нэр үгээр илэрнэ.

# Эхийн сэдэв, гол санааг түлхүүр үгээр тодорхойлоорой.


Түлхүүр үгсийн аль нь эхийн сэдэв болохыг тэмдэглэх



Гол сэдвээ олсны дараа түлхүүр үгсээр холбоо хамаарлыг эхийн хэсэг тус бүрээр гарган загварчлах



Загварыг ажиглаад, эхийн гол санааг дүгнэх



# Мэдлэг, ойлголтоо нэгтгэн дүгнээрэй.

## Сэдэв

Эхийн гол санааг гаргахын тулд сэдэн дэвшүүлсэн санааг хэлнэ. Эхийн сэдэв нь юуны тухай? гэсэн асуултад хариулагдана.

## Гол санаа

Сэдвээр дамжуулан гаргасан дүгнэлт санааг хэлнэ.

## Түлхүүр үг

Түлхүүр үг гэдэг нь эхэд олон давтагдаж орсон болон сэдвийн хүрээнд утгыг гаргахад чухал үүрэгтэй үг хэллэгийг хэлнэ. Түлхүүр үг нь ихэвчлэн нэр үгээр илэрнэ.

## Түлхүүр өгүүлбэр

Тухайн цогцолбор буюу догол мөр бүрийн сэдвийн тухай мэдээлсэн өгүүлбэрийг хэлнэ. Ихэвчлэн цогцолборын эхэнд байрладаг.

